



## **Оюу Толгой ХХК**

Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчны  
удирдлагын тогтолцооны журам

10-р хэсэг. Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам  
(СЗ Тээврийн хэрэгслийн болон жолоодлогын аюулгүй  
ажиллагааны стандарт)

**Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам**Хүчин төгөлдөр болох огноо:  
2012.04.16Баримтын дугаар:  
ОТ-10-СЗ-PRC-0002-МХувилбар:  
1.1**1 ЗОРИЛГО**

Энэхүү журмын зорилго нь хүнд даацын тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээг ашиглалтын шаардлага хангах хэмжээнд хийх, эдгээр машин механизмыг алслагдсан Говийн бүс нутаг дахь Оюу Толгойд аюулгүй ажиллуулах мэргэжлийн ур чадварыг жолооч буюу операторуудад олгох замаар хүн гэмтэж бэртэх, эд хөрөнгөд хохирол учрах эрсдлийг багасгахад оршино.

Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах нь эрсдэл өндөртэй ажиллагаа гэж Оюу Толгой ХХК болон Рио Тинто Группын хэмжээнд тооцогддог.

**2 ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэхүү журам нь Оюу Толгойн бүх ажилчид, гүйцэтгэгчдэд хамаарах бөгөөд Оюу Толгой ХХК-ийн, эсвэл Оюу Толгой ХХК-ийн бизнест оролцон төслийн талбай дээр эсвэл төслийн талбайгаас бусад газарт ажиллаж байгаа гэрээт гүйцэтгэгчдийн эзэмшиж, ашиглаж байгаа бүх замууд үүнд хамаарна.

**3 АЖИЛ ҮҮРЭГ БА ХАРИУЦЛАГА**

Ажил үүрэг	Хариуцлага
Ажилчид, Гүйцэтгэгчид болон Зочид	<ul style="list-style-type: none"><li>Тээврийн хэрэгслийг заасан хурдны хязгаарын дотор, нөхцөл байдалд тохируулан анхаарал, болгоомжтой жолоодно.</li><li>Оюу Толгой ХХК-ийн Архи болон мансууруулах бодисын талаар баримтлах бодлогын дагуу, архи болон бусад мансууруулах бодисын нөлөөнд байгаа хүмүүс тээврийг хэрэгсэл жолоодож болохгүй.</li><li>Жолоо барих үед гар утас хэрэглэхийг хориглоно.</li><li>Аюулгүй ажиллагааны үүднээс шаардлагатай байхаас бусад тохиолдолд тээврийн хэрэгслийг жолоодох үедээ тээврийн хэрэгслийн цонхыг хааж явна.</li><li>Тээврийн хэрэгсэл явж байх үед жолооч, болон зорчигчид суудлын бүсээ байнга зүүх ёстой.</li><li>Тээврийн хэрэгсэл гэнэт зогсох үед шидэгдэх боломжтой аливаа эд зүйлийг найдвартай бэхэлсэн байна.</li><li>Аливаа тээврийн хэрэгслийг хүнээр түрүүлэх буюу түрж асаахыг хориглоно.</li><li>Хүнд даацын тээврийн хэрэгслээс бусад тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт машин механизмыг хэзээ ч асаалттайгаар орхиж болохгүй. Хүнд даацын тээврийн хэрэгслийг хүнгүй орхих бол тухайн төрлийн тээврийн хэрэгслийг зогсоолд тавих журамд заасны дагуу зогсоолд тавина.</li><li>Монгол Улсын хуульд заасны дагуу хүчин төгөлдөр жолооны үнэмлэхтэй байна.</li><li>Тээврийн хэрэгслийн аюулгүйн болон ажиллуулахын өмнөх үзлэгийг хийнэ.</li><li>Тээврийн хэрэгслийн аливаа доголдол, эвдрэлийг аль болох хурдан мэдэгдэнэ;</li><li>Тээврийн хэрэгслийн аюулгүй ажиллагаанд нөлөөлөх аливаа эвдрэл, доголдол (жишээлбэл тоормос, жолоо) гарсан бол нэн даруй мэдэгдэж “АЖИЛЛАГААГҮЙ” гэсэн шошго зүүнэ.</li></ul>

**Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам**

Хүчин төгөлдөр болох огноо:  
2012.04.16

Баримтын дугаар:  
ОТ-10-СЗ-PRC-0002-M

Хувилбар:  
1.1

	<ul style="list-style-type: none"> <li>Тээврийн хэрэгслийг цэвэр, эмх цэгцтэй байлгана.</li> </ul>
<b>Супервайзор</b>	<ul style="list-style-type: none"> <li>Аливаа хүнд Оюу Толгойн тээврийн хэрэгслийг жолоодоох зөвшөөрөл өгөхөөс өмнө дараахь алхамуудыг хийнэ:             <ul style="list-style-type: none"> <li>Жолооны үнэмлэхийг шалгана.</li> <li>Жолооч тээврийн хэрэгсэлтэй танилцаж, ажиллуулахын өмнөх аюулгүй ажиллагааны үзлэг, ажлын дараа хийх үйлдлүүдийг мэдэж авсан байна.</li> <li>Жолооч энэхүү журмын агуулгыг мэдэж авсан байна.</li> <li>Аюулгүй жолоодлогын ажиглалт хийсэн байна.</li> </ul> </li> <li>Өөрийн шууд удирдлагад буй ажилтан нэг бүрийн жолооны үнэмлэхний үзлэг, аюулгүй жолоодлогын ажиглалтыг жил тутам хийнэ.</li> <li>Түрээсэлж, эзэмшиж, хөлсөлж буй тээврийн хэрэгсэлд, үйлдвэрлэгчээс гаргасан зөвлөмж, лизингийн буюу түрээсийн байгууллагын гаргасан зааврын дагуу засвар үйлчилгээ хийнэ.</li> </ul>
<b>Суперинтендент</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын зорилгоор жолоодох бүх тээврийн хэрэгсэлд, тухайн тээврийн хэрэгслийн эрсдлийн дүн шинжилгээ болон зан төлөвийн хүчин зүйлүүд дээр үндэслэн, ажиллуулахын өмнөх аюулгүй ажиллагааны зохих үзлэг шалгалтыг хийнэ.</li> <li>Зогсолтгүйгээр ашиглаж байгаа тоног төхөөрөмжид тогтсон стандартын дагуу аюулгүй ажиллагааны үзлэг шалгалтыг ээлж болгонд хийнэ.</li> <li>Ховор ашигладаг тоног төхөөрөмжийг ажиллуулахын өмнө шалгана.</li> <li>Тээврийн хэрэгсэлд хийсэн үзлэг шалгалт бүрийг холбогдох шалгах хуудсанд бүртгэж, нэг хувийг нь тээврийн хэрэгсэлд үлдээнэ.</li> <li>Тээврийн хэрэгсэлд илэрсэн эвдрэл, доголдлыг мэдээлэх, засварлах журам гаргасан байна.</li> <li>Замд гаргах боломжгүй тээврийн хэрэгсэлд “ажиллагаагүй” гэсэн шошго зүүх бөгөөд ашиглаж болохгүй.</li> <li>Оюу Толгойн түрээсэлж, эзэмшиж буй хөнгөн тэрэг, микро автобус, ачааны машиныг Тээврийн хэрэгслийн тоноглол гэсэн хэсэгт заасан шаардлагын дагуу тоноглон байна.</li> <li>Тээврийн хэрэгслийг тогтмол цэвэрлэсэн байна.</li> </ul>
<b>Дараагийн шатны Удирдлага (LOR) / Менежер</b>	<ul style="list-style-type: none"> <li>Ажлын зорилгоор ашиглаж буй бүх тээврийн хэрэгсэлд <i>Рио Тинтогийн СЗ Тээврийн хэрэгслийн болон жолоодлогын аюулгүй ажиллагааны стандартад</i> заасан шаардлагын дагуу эрсдлийн дүн шинжилгээ хийх ёстой. Эрсдлийн дүн шинжилгээг тээврийн хэрэгсэлд байрлуулна.</li> <li>Бүх тээврийн хэрэгсэл нь Тээврийн хэрэгслийн нөхцөл байдал хэсэгт заасан шаардлагад нийцсэн байх ёстой.</li> <li>Ажлын зорилгоор ашиглаж, түрээсэлж байгаа бүх тээврийн хэрэгсэлд тухайн төрлийн тээврийн хэрэгслийн эрсдлийн дүн шинжилгээнд тохирсон давтамжтайгаар, ажиллуулахын өмнөх аюулгүй ажиллагааны үзлэг шалгалт хийх тогтолцоог</li> </ul>

<b>Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам</b>		
Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16	Баримтын дугаар: ОТ-10-СЗ-PRC-0002-M	Хувилбар: 1.1

	<p>бүрдүүлнэ.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Бүх тээврийн хэрэгсэлд бүртгэл хөтөлнө.</li> <li>• Холбогдох журмын дагуу тээврийн хэрэгслийг бүртгэж, гэрчилгээжүүлж, даатгуулна.</li> <li>• Оюу Толгойн Сургалт, үнэлгээний холбогдох стандартын дагуу сургалтанд хамрагдаж, мэргэшиж, шалгалт өгч, тухайн тээврийн хэрэгслийг жолоодох үнэмлэх аваагүй аливаа хүнээр тээврийн хэрэгсэл жолоодуулдаггүй байх тогтолцоог бүрдүүлнэ. Уг сургалтаар, тухайн тээврийн хэрэгсэлд хийсэн эрсдэлийн дүн шинжилгээгээр тогтоосон аюул осол, тухайн тээврийн хэрэгслийг ашиглан гүйцэтгэх ажлуудын талаар зааж сургана. Жолоочид зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагуудыг Жолоочид зөвшөөрөл олгох гэсэн хэсэгт нарийвчлан тайлбарласан.</li> <li>• Хүнд даацын тээврийн хэрэгсэл болон үйлдвэрлэлийн талбайд ажлын зорилгоор хөнгөн тээврийн хэрэгсэл жолоодох бүх хүмүүс Жолоочийн шалгах хуудсыг жил тутам бөглөж аюулгүй жолоодлогын арга барилаа сайжруулна.</li> <li>• Зориулалтын бус тээврийн хэрэгслийг өөр тээврийн хэрэгсэл чирэхэд ашиглаж болохгүй.</li> <li>• Нийтийн зам талбайд болсон тээврийн хэрэгслийн зөрчил, ослыг хууль тогтоомжид заасны дагуу орон нутгийн засаг захиргааны байгууллагад мэдэгдэнэ. Компанийн тээврийн хэрэгсэл оролцсон осол, замын хөдөлгөөний дүрмийн зөрчлийг мэдэгдэж, шалгалт хийх ёстой.</li> </ul>
<b>Хэлтсийн Ерөнхий Менежер</b>	<p>Тээврийн хэрэгслийн болон жолоодлогын аюулгүй ажиллагаанд нөлөөлөх нөхцөл байдлын ба зан төлөвийн хүчин зүйлүүдийг тодорхойлох эрсдлийн цогц дүн шинжилгээг <i>Аюулгүй ажиллагааны стандарт - СЗ Тээврийн хэрэгслийн болон жолоодлогын аюулгүй ажиллагааны стандартын [ОТ-10-СЗ-STD-0003-E]</i> шаардлагын дагуу төслийн талбай тус бүрээр хийсэн байна.. Дүн шинжилгээгээр илэрсэн асуудлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөөг төслийн талбай тус бүрээр боловсруулж, гүйцэтгэлийг хянана.</p> <p>Хурдны хязгаар, замын тэмдэглээ, замын хөдөлгөөний дүрмийг тогтмол хянаж шалгах, биелэлтийг хангах ажлыг төслийн талбайн СЗ стандартын хороо болон ЭМААБО-ны хэлтэс хариуцна.</p>

## 4 ЖУРАМ

### 4.1 ЖОЛООЧИД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

#### 4.1.1 Хөдөлгөөнт машин механизм

Хөдөлгөөнт машин механизмын операторууд нь AS2359.2 SAA Үйлдвэрийн ачааны машины дүрэм –2-р хэсэг: Ажиллуулах гэсэн стандартын шаардлагуудыг хангасан байна. Мөн хөдөлгөөнт машин механизмын операторууд:

- Монгол Улсад механикжсан тээврийн хэрэгсэл жолоодох хүчин төгөлдөр, ямар нэгэн хязгаарлалтгүй жолооны үнэмлэхтэй

**Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам**Хүчин төгөлдөр болох огноо:  
2012.04.16Баримтын дугаар:  
ОТ-10-СЗ-PRC-0002-МХувилбар:  
1.1

- 18-аас дээш настай
- Тоног төхөөрөмжийг ажиллуулах ур чадвар эзэмшиж, зохих зөвшөөрөл авсан байна.

**4.2 Хэт ядрах**

Жолооч болон зорчигчид, хэт ядарсан үед илрэх шинж тэмдгүүдийг мэддэг, таних чадвартай байх ёстой бөгөөд супервайзортаа мэдэгдэх, зогсож амрах эсвэл жолоочоо солих зэрэг арга хэмжээ авна.

**4.3 Тээврийн хэрэгслийн нөхцөл байдал**

Ажлын зорилгоор ашиглаж, түрээсэлж буй бүх тээврийн хэрэгсэл нь замд гаргах боломжтой, жолооч болон бүх зорчигчдод хүрэлцэхүйц зориулалтын суудал, суудлын бүсээр тоноглогдсон байна.

Хурдны хязгаарын хамгийн бага хэмжээг хэтрүүлэх техникийн боломжтой бүх тээврийн хэрэгсэлд хурд хэмжигч буюу түүнтэй адилтгах төхөөрөмжөөр тоноглогдсон, эсвэл хурдны хязгаараас хэтрүүлэх боломжгүй болгож хязгаарласан байна.

Зориулалтын бус тээврийн хэрэгслээр бусад машин механизмыг чирэх буюу татан гаргахыг хориглоно (Хавсралт А-г харна уу).

Замд гаргах боломжгүй машин механизмд Тусгаарлалт хийх журмын дагуу “АЖИЛЛАГААГҮЙ” гэсэн шошго зүүх бөгөөд ашиглахыг хориглоно.

**4.3.1 Тээврийн хэрэгслийн ажиллуулахын өмнөх үзлэг, шалгалт**

Тээврийн хэрэгслийн ажиллуулахын өмнөх үзлэг нь тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээхийсэн, тоног төхөөрөмж бүрэн, оператор нь тээврийн хэрэгсэлтэй танилцсан эсэхийг нягтлах зорилготой.

Бүх тээврийн хэрэгсэлд ажиллуулахын өмнөх үзлэгийг долоо хоногт нэгээс доошгүй удаа хийнэ.

Зогсолтгүй ээлжээр ажиллуулж буй тээврийн хэрэгсэлд ээлж солилцохын өмнө үзлэг хийнэ. Ашиглалтын шаардлагаар ээлж солилцох үед үзлэг хийх боломжгүй бол, үзлэгийг ээлжийн дундуур хийнэ.

Тээврийн хэрэгсэлд хийсэн бүх үзлэгийг холбогдох шалгах хуудсанд бүртгэнэ. Шалгах хуудсын нэг хувийг супервайзорт хүлээлгэж өгнө.

**4.3.2 Ажлын дараа жолоочийн хий ажил**

Ээлжээ дууссаны дараа жолооч нар тээврийн хэрэгслийг цэвэрлэж, доголдол гарсан бол мэдээлэх ёстой.

**4.4 Тээврийн хэрэгслийн тоноглол**

Төслийн талбайд ашиглах тээврийн хэрэгслүүд дараах төхөөрөмжөөр тоноглогдсон байна:

- Тээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчээс гаргасан Операторын гарын авлага,
- Гал унтраагуур,
- Гурван цацруулагчтай аюулгүйн гурвалжин; хүнд даацын тээврийн хэрэгсэлд ашиглахгүй,

**Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам**Хүчин төгөлдөр болох огноо:  
2012.04.16Баримтын дугаар:  
ОТ-10-СЗ-PRC-0002-МХувилбар:  
1.1

- Хоёр дугуйн ивээс

**4.5 Суудлын бүс**

Тээврийн хэрэгсэлд сууж байгаа хүн бүр тээврийн хэрэгслийг хөдөлж байх үед зориулалтын суудлын бүс зүүнэ.

**4.6 Хурдны хязгаар**

Төслийн талбай дахь хурдны хязгаар болон замын хөдөлгөөний дүрмийг тогтмол хянаж байна.

**4.6.1 Хурдны хязгаар - Ерөнхий**

Хурдны хязгаарын тэмдэг нь тухайн замын хэсэгт хэвийн нөхцөлд зөвшөөрөгдөх хамгийн дээд хурдыг заана. Тэмдэгт заасан хурдны хязгаарыг хэтрүүлж болохгүй.

**4.6.2 Хурдны хязгаар – Шороон замд**

Жолооч нар шороон зам дээр явах үедээ замын нөхцөл байдалд сонор сэрэмжтэй хандаж, хурдаа тохируулах ёстой.

**4.7 Эсрэг урсгалын замын хөдөлгөөн**

Өөдөөс ирж байгаа тээврийн хэрэгсэлд дөхөх, зөрж өнгөрөх үед онцгой анхааралтай байна.

**4.8 Тээврийн хэрэгслийг зогсоолд тавих**

Бүх тээврийн хэрэгслийг хөдлөхөөргүй болгож зогсоолд тавина. Тээврийн хэрэгсэл хөдөлгөөнгүй байж чадахааргүй бол дугуйнд ивээс хийнэ.

Хүнгүй орхисон тээврийн хэрэгслийг хөдлөхөөргүй болгож зогсоолд тавина. Мөн:

- Цаг агаар хүйтэн байх үед эрсдлийн дүн шинжилгээний дагуу хүнд даацын тээврийн хэрэгслийг асаалттай орхихоос бусад тохиолдолд, , аливаа тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт машин механизмыг хэзээ ч асаалттай орхиж болохгүй. Хүнд даацын тээврийн хэрэгслийг хүнгүй орхих тохиолдолд, тухайн төрлийн тээврийн хэрэгслийг зогсоолд тавих журмын дагуу зогсоолд тавина.
- Гар тоормосыг бүрэн татна.
- Тээврийн хэрэгслийг араатай үлдээнэ.

**4.9 Их гэрэл**

Тээврийн хэрэгсэл ажиллаж байх үед их гэрлээ байнга асаалттай байлгана.

**4.10 Шороон зам дээр машин жолоодох**

Шороон зам дээр машин жолоодох үед тээврийн хэрэгслийн дугуйг, замын гадаргуутай сайн авцалдуулж, хий эргүүлэхгүй байх нь чухал бөгөөд . дугуй хий эргэхээргүй хурдтай явах, сайн ажиглаж, замаа зөв сонгож явах хэрэгтэй.

**4.11 Устай саадыг гатлах**

Шороон зам дээр тогтсон ус тээврийн хэрэгслийн ажиллагаанд ихээхэн саад учруулдаг.

## Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам

Хүчин төгөлдөр болох огноо:  
2012.04.16

Баримтын дугаар:  
ОТ-10-СЗ-PRC-0002-М

Хувилбар:  
1.1

Жолооч нар дор дурдсан нөхцөлийг магадлалгүйгээр ус туулж болохгүй. Үүнд:

- Усны гүн нь 0.5 метрээс бага эсэх,
- Усны урсгалын эрч нь тээврийн хэрэгслийг урсгаж замаас гаргахааргүй эсэх,
- Замын гадаргуу тогтвортой, усанд угаагдаж эвдрээгүй, эсвэл зам дээр шавар, шороо овоороогүй эсэх.

Усны гүн, урсгалын эрчийг шалгах, усанд автсан замын нөхцөлийг тодорхойлох зорилгоор өөрийгөө эрсдэлд оруулж болохгүй.

### 4.12 Тээврийн хэрэгслийг түрж асаах

Тээврийн хэрэгслийг түрж асаахыг хориглоно.

### 4.13 Гэрэл дохио

Уурхайн талбай болон бусад ажлын талбар (тухайлбал, барилгын талбай) дээр ажиллах тээврийн хэрэгслийг гэрэл дохиогоор тоноглон байх бөгөөд гэрэл дохиог тухайн талбайд мөрдөгддөг шаардлагын дагуу ажилуулна.

Гэрэл дохиог машины бүхээг дээр авагддаггүй байдлаар, эсвэл авагддаг байдлаар соронздож тогтоож болно.

Оюу Толгой төслийн талбайгаас өөр газарт явж байгаа хөнгөн тэрэгний гэрэл дохиог ажиллуулахгүй. Аливаа аюултай нөхцөл байдлыг, тухайлбал осол аваар, замын саадыг ойртон ирж байгаа тээврийн хэрэгсэлд анхааруулахын тулд гэрэл дохиог ажиллуулна.

### 4.14 Эвдрэл, ослын үед баримтлах болон татан гаргах журам

Тээврийн хэрэгсэл эвдрэх үед жолооч нь ил уурхайн диспетчер болон супервайзортайгаа холбоо барих ба тэд цааш нь Хүнд даацын тээврийн хэрэгслийн засварын супервайзорт мэдэгдэж машиныг засварлах эсвэл татан гаргах ажлыг зохион байгуулна.

Тээврийн хэрэгслийг хөдлөхөөргүй болгоно.

Тээврийн хэрэгсэл осолд орж, эвдэрсэн бол ослын шинжилгээ хийх хүртэл тээврийн хэрэгслийг татаж гаргалгүй хүлээнэ. Тухайн тээврийн хэрэгсэл нь бусад замын хөдөлгөөнд оролцогч нарт аюул учруулахаар байвал, ил уурхайн диспетчерт мэдэгдэж тээврийн хэрэгслийг ослын газраас зайлуулах ажлыг зохион байгуулна.

Татан гаргах ажлыг зөвхөн мэргэшсэн ажилтан хийж гүйцэтгэнэ. Тээврийн хэрэгслийг татан гаргах ажиллагааг хавсралт А-д үзүүлсэн.

#### 4.14.1 Дугуй хагарсан үед мөрдөх журам

Тээврийн хэрэгслийн дугуй хагарсан тохиолдолд жолооч нь ил уурхайн диспетчер болон супервайзортайгаа холбоо барина.

### 4.15 Тээврийн хэрэгсэлд авч явахбичиг баримт

Бүх тээврийн хэрэгсэлд энэхүү журмын хувийг тээврийн хэрэгслийн эрсдлийн дүн шинжилгээний хамтаар авч явна.

**Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам**

Хүчин төгөлдөр болох огноо:  
2012.04.16

Баримтын дугаар:  
ОТ-10-СЗ-PRC-0002-М

Хувилбар:  
1.1

**5 ТОДОРХОЙЛОЛТ**

**Тээврийн хэрэгсэл:** Ажлын зорилгоор ашиглагдах аливаа механикжсан дугуйт тээврийн хэрэгсэл, хөнгөн тэрэг болон хөдөлгөөнт машин механизмыг хэлнэ. Галт тэрэгний зүтгүүр болон төмөр замын машин механизм үүнд хамаарахгүй.

**Байх ёстой:** Шаардлагыг заавал биелүүлэх ёстой гэж ойлгоно.

**Байвал зохино:** Шаардлагыг зөвлөмж болгосон гэж ойлгоно

**Хөнгөн тэрэг:** 4.5 тонноос бага нийт жинтэй аливаа хуурай газрын тээврийн хэрэгсэл.

**Хүнд даацын тээврийн хэрэгсэл:** Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдах, талбайн нэг хэсгээс нөгөө рүү өөрийн хүчээр хүрч очих том оврын тээврийн хэрэгсэл, машин механизм.

**Хүнгүй орхисон тээврийн хэрэгсэл:** Тээврийн хэрэгслийг ажиллуулах мэргэшсэн ажилтан тухайн тээврийн хэрэгслийн жолоон дээр байхгүй бол уг хүнгүй орхисон тээврийн хэрэгсэл гэнэ.

**Хөдлөхөөргүй:** Хөдөлгөөнт машин механизмыг араанд нь хийгээгүй, тоормос болонгар тоормосыг ажиллуулаагүй байдлаар орхисон үед уг машин механизм өнхрөхгүй буюу хөдлөхгүй байхыг хөдлөхөөргүй гэж тооцно.

**6 АШИГЛАСАН БОЛОН ХОЛБОГДОЛТОЙ БИЧИГ БАРИМТ**

	Нэр	Байршил
Хуулийн болон бусад шаардлага	Рио Тинто компанийн ЭМААБОЧ-ын 10-р хэсэг. Үйл ажиллагааны хяналт	Проспект
Оюу Толгойн ЭМААБО-ны удирдлагын систем	Элемент 10 – Үйл ажиллагааны хяналт	ЭМААБО-ы Портал хуудас
	ОТ-10-PRC-0005-Е-HSE Стандартчилсан тэмдэг, тэмдэглэгээний журам	
	ОТ-10-СЗ-PRC-0005-Е-Замын хөдөлгөөний удирдлагын төлөвлөгөө	
	ОТ-10-СЗ-PRC-0006-Е- Ажлын зөвшөөрөл олгох журам	
	ОТ-10-СЗ-PRC-0002-Е- Хөнгөн тэрэгний ашиглалтын журам	
	ОТ-10-СЗ-PRC-0003-Е-Хүнд даацын тээврийн хэрэгслийн ашиглалтын журам	
	ОТ-10-СЗ-PRC-0001-Е- Зам барих, засвар үйлчилгээ хийх журам	

**7 БАРИМТ БИЧГИЙН ХЯНАЛТ**

Файлын нэр	ОТ-10-СЗ-PRC-0002-М-ОТ Хүнд тээврийн хэрэгсэл ажиллуулах журам
Тайлбар	Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам
Эх зохиогч (д)	Клем Тёрнер Моррис Дзус
Зохиосон огноо	2012.03.01
Баталсан	Эндрю Миллер
Баталсан огноо	2012.04.16
Бүртгэл өөрчлөгдсөн дугаар	##



## ОЮУ ТОЛГОЙ ХХК

**Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам**

Хүчин төгөлдөр болох огноо: 2012.04.16	Баримтын дугаар: ОТ-10-СЗ-PRC-0002-М	Хувилбар: 1.1
-------------------------------------------	-----------------------------------------	------------------

Эрсдлийн зэрэг	Үнэлгээ хийсэн огноо	Эрсдлийн үнэлгээ хийсэн	Хяналт хийх хуваарь	Дараагийн хяналт хийх огноо
Дунд	2012.04.16	Эндрю Миллер	2 жил тутам	2014.04.16

Хувилбар	Өөрчлөлт хийсэн огноо	Зохиосон хүн (хүмүүс)	Баталсан	Өөрчлөлтийн тайлбар
1.0	2012.04.16	Клем Тёрнер Моррис Дзус	Эндрю Миллер	Анхны хувилбар
1.0	2012.04.16	Клем Тёрнер Моррис Дзус	Эндрю Миллер	Батлагдсан хувилбар
1.1	2012.12.26	Н. Тогтуур	Б. Долгор	Бичиг баримтанд хяналт хийгдсэн бөгөөд утга санааг нь өөрчлөөгүй болно

**Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам**Хүчин төгөлдөр болох огноо:  
2012.04.16Баримтын дугаар:  
ОТ-10-СЗ-PRC-0002-МХувилбар:  
1.1**8 ХАВСРАЛТ А – Тээврийн хэрэгслийг татан гаргах журам****8.1 Зорилго**

Энэхүү журмын зорилго нь тээврийн хэрэгслийг татан гаргах ажлыг аюулгүйгээр гүйцэтгэхэд оршино.

**8.2 Хамрах хүрээ**

Энэхүү журам нь нэг тээврийн хэрэгслийг нөгөөгөөр нь татаж гаргах ажиллагаанд хамаарна.

**8.3 Зорилт**

Энэхүү журмын зорилт нь тээврийн хэрэгслийг татаж гаргахажлыг хийхийн өмнө уг ажлыг аюулгүйгээр гүйцэтгэхэд нөлөөлөх бүхий л хүчин зүйлсийг өмнө авч үзсэн байхад оршино.

**8.4 Журам**

Тээврийн хэрэгслийг татаж гаргахад шаардагдах хүчний хэмжээ хэд хэдэн хүчин зүйлээс шалтгаална. Эдгээр хүчин зүйлст тухайн татан гаргах ажиллагааны нөхцөл, татаж болон татуулж буй төхөөрөмж, тээврийн хэрэгсэлүүдийн хоорондох холбоосын өөрийн онцлогоос шалтгаална.

Татаж гаргах ажиллагааг аюулгүй гүйцэтгэхийн тулд дараах хүчин зүйлсийг харгалзаж үзнэ:

Төхөөрөмжийг татаж гаргахад шаардагдах нийт хүч. Энэ нь дараах зүйлсээс хамаарна:

- Татаж гаргах төхөөрөмжийн жин (тээврийн хэрэгслийн нийт жин).
- Татаж гаргах төхөөрөмжийн өнхрөлтийн эсэргүүцэл.
- Татаж гаргах төхөөрөмжийн налууугийн эсэргүүцэл.

Татах төхөөрөмжийн нийт ашиглаж болох хүч. Энэ нь дараах зүйлсээр тодорхойлогдоно:

- Татах төхөөрөмжийн жин.
- Татах төхөөрөмжийн өнхрөлтийн эсэргүүцэл.
- Татах төхөөрөмжийн налууугийн эсэргүүцэл.
- Татах төхөөрөмжийн замтай авцалдах байдал.

Татах болон татаж гаргах төхөөрөмжийн хоорондох холбоосын хүчин чадал. Үүнд:

- Татаж гаргах төхөөрөмжийн холбох цэгүүдийн хүчин чадал, байдал.
- Татах төхөөрөмжийн холбох цэгүүдийн хүчин чадал, байдал.
- Татаж гаргах ажиллагаанд ашиглах аливаа гинж, дэгээ, бусад холбоосын хүчин чадал.

Динамик хүч – Татаж гаргах ажиллагааны үед хөдөлгөөнгүй байгаа төхөөрөмжид хүч үйлчилсний улмаас динамик хүч үүснэ. Эдгээр динамик хүчний шинж чанарыг ойлгох хэрэгтэй бөгөөд шаардлагатай тохиолдолд (жишээлбэл налуу газар татан гаргаж байгаа төхөөрөмжийг тоормослох) үүнийг тооцсон байх ёстой.

**8.5 Хариуцлага**

**Хүнд даацын тээврийн хэрэгслийг ажиллуулах журам**Хүчин төгөлдөр болох огноо:  
2012.04.16Баримтын дугаар:  
ОТ-10-СЗ-PRC-0002-МХувилбар:  
1.1

Ажиллагааг удирдаж байгаа хүн татаж гаргах ажиллагааг аюулгүй гүйцэтгэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг харгалзан үзэж уг ажиллагаанд ашиглах бүх төхөөрөмжийг сонгож авах ажлыг хариуцна.

Үүнээс гадна, татуулахаар хүлээгдэж буй төхөөрөмжийг хөдлөхөөргүй болгосон байх ёстой.

**8.6 Тодорхойлолт**

**Өнхрөлтийн эсэргүүцэл** гэдэг нь дугуйг газар дээгүүр өнхрүүлэх, татахад тулгарах эсэргүүцэл. Энэ эсэргүүцэл нь газрын нөхцөл байдал болон тээврийн хэрэгслийн нийт жингээс (ачааг оролцуулаад) хамаарна. Өнхрөлтийн эсэргүүцлийг машины нийт жингийн (Механизмын нийт жин, Тээврийн хэрэгслийн нийт жин) эзлэх хувиар хэмжигдэх бөгөөд килограмаар илэрхийлэгдэнэ.

Дугуйн хий нь өнхрөлтийн эсэргүүцлийг ихэсгэж эсвэл багасгаж болно. Хийгүй дугуй, хийлсэн дугуйнаас илүү их эсэргүүцэлтэй байдаг, гэхдээ хийг нь багасгасан дугуй нь шавар буюу элстэй замд өнхрөлтийн эсэргүүцлийг багсгана.

**Налуугийн эсэргүүцэл** гэдэг нь машиныг ашиггүй налуутай газар (тухайлбал өөд газар) хөдөлгөхөд тулгарах эсэргүүцэл юм. Налууг ихэвчлэн хэвгийн хувиар хэмждэг бөгөөд энэ нь тухайн налуугийн босоо тэнхлэгийн дагуух өндрийн зөрөөг хэвтээ тэнхлэгийн дагуух зайд харьцуулсан харьцаа юм. Налуугийн эсэргүүцэл нь налуугийн 1% тутамд тээврийн хэрэгслийн нийт жингийн 1%-тай тэнцэх бөгөөд килограмаар илэрхийлэгдэнэ.

**Налуугийн дэм** гэдэг нь машиныг ашигтай налуутай газар (тухайлбал уруу газар) хөдөлгөхөд үүсэх дэм юм. Налууг ихэвчлэн хэвгийн хувиар хэмждэг бөгөөд энэ нь тухайн налуугийн босоо тэнхлэгийн дагуух уналыг хэвтээ тэнхлэгийн дагуух зайд харьцуулсан харьцаа юм. Налуугийн дэм нь налуугийн 1% тутамд тээврийн хэрэгслийн нийт жингийн 1%-тай тэнцэх бөгөөд килограмаар илэрхийлэгдэнэ.

**Нийт эсэргүүцэл** гэдэг нь өнхрөлтийн эсэргүүцэл ба налуугийн эсэргүүцлийн (эсвэл дэмийн) хавсарсан үйлчлэлийг хэлнэ. Энэхүү нийлбэр нь килограмаар илэрхийлэгдэх эсэргүүцэл болно.

**Авцалдалт** гэдэг нь дугуй буюу тракторын гинж замын гадаргуутай харилцан үйлчлэхэд үүсэх зүтгэх хүч юм. Авцалдалт нь хөтлөгч дугуйны (эсвэл гинжний) жин, дугуйны (эсвэл гинжний) зууралт, замын нөхцлөөс хамаарна.

Тээврийн хэрэгслийн нийт жин гэдэг нь баглаа боодол, ашигт ачаа, түлш, жолооч, зорчигч нарын жинг оролцуулсан тээврийн хэрэгслийн нийт жин юм.

**Динамик хүч** гэдэг нь хөдөлгөөний хүч буюу хөдөлгөөний улмаас үүсэх хүч юм.